

НИЙСЛЭЛ ХОТЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2022 оны эхний хагас жилийн байдлаар)

2022 оны 06 дугаар сарын 09

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн Нийслэл хотын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг 2022 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн дүгнэж, явцын хяналт- шинжилгээ үнэлгээ хийлээ.

Нийслэл хотын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тус газар хэрэгжүүлэхээр тусгагдсан 3 зорилт 9 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 43.3% буюу 1 арга хэмжээ 90%, 1 арга хэмжээ 70%, 2 арга хэмжээ 50%, 1 арга хэмжээ 40%, 1 арга хэмжээ 30%, 1 арга хэмжээ 0%-тай байна.

Тус газрын хариуцан хэрэгжүүлэхээр туссан арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 43.3%-тай байгаа нь 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-т заасан үнэлгээний арга зүйгээр “Эрчимжүүлэх шаардлагатай”- (зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай) үнэлгээтэй байна.

Хэрэгжилт 90-100 хувьтай заалтад:

- ✚ Зорчигч тээврийн урсгалаас хамаарч дагуу, хаяа хот, тосгод нийтийн тээврийн сүлжээнд холбогдсон байна. /9.21.2./

Хэрэгжилт 50-89 хувьтай заалтад:

- ✚ Зорчигч тээврийн үйлчилгээний зогсоолыг сайжруулж, стандартын дагуу байгуулна. - Шинээр баригдах нийтийн тээврийн зогсоол /9.22.3.1./

-Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолд байршуулах мэдээллийн самбар /9.22.3.2 /

- Нийтийн тээврийн үйлчилгээний тохижуулах зогсоолын тоо /9.22.3.3 /

Хэрэгжилт 10-49 хувьтай заалтад:

- ✚ Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй автобусаар парк шинэчлэлт хийсэн байна. /9.22.1./
- ✚ Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулж, нийтийн тээврийн төлөвлөлт оновчтой төлөвлөгдсөн байна. /9.21.1./
- ✚ Нийтийн тээврийн үйлчилгээнд олон төрөлт, ухаалаг зорчигч тээврийн төрөл нэмэгдсэн байна. /9.21.3./
- ✚ Цахилгаан тээврийн хэрэгслийг цахилгаан эх үүсвэрээр цэнэглэх цэгийг байгуулсан байна. /9.22.2./

Хэрэгжилт 0-9 хувьтай заалтад:

- ✚ Улаанбаатар хотын зүүн, баруун хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна.

- Зорчигчийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорчигчийн нэгдсэн терминалын тоо /9.23.1/

ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2.1. Даргын зөвлөлийн хурлаас Нийслэл хотын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлантай холбоотой өгсөн үүрэг даалгаврыг холбогдох хэлтсийн дарга нарт хүргүүлж, хэрэгжилтэд явцын хяналт тавих;

2.2. Нийслэл хотыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хариуцаж байгаа холбогдох хэлтсийн дарга нар Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, 2000 тэмдэгтэд багтаасан, товч, тодорхой тайлан мэдээг хугацаандаа өгч байхыг анхааруулах;

2.3. Цаашид арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах, удаашралтай байгаа ажлыг холбогдох байгууллагатай хамтран үр дүнтэй шийдвэрлэхийг Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр холбогдох хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэгжүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭЙТГЭГЧ

Ч.САЙХАНБАЯР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

З.ЦЭВЭЭНДОРЖ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.БОЛОРЦЭЦЭГ

**НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2022 оны 06 дүгээр сарын 08

2022 оны эхний хагас жилийн байдлаар

Д/д	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан нөхцөл тайлбар)	Хэрэгжилтийн хувь
				Он	Түвшин			
1.	Зорилт 9.21. Улаанбаатар хотод олон төрөлт тээврийн оновчтой сүлжээг төлөвлөн, хэрэгжүүлнэ.							
1.1	9.21.1. Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулж, нийтийн тээврийн төлөвлөлт оновчтой төлөвлөгдсөн байна.	-	Нийтийн тээврийн чиглэлийн давхцал буурах хувь	2021	50	50	Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/900 дугаар захирамжаар Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх 7 төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан. Дээрх захирамжийн хүрээнд: 1.Шинэ төрлийн их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгслийн харьцуулсан судалгаа /эхлэлийн болон дундын тайлан боловсруулагдсан, гүйцэтгэл 80%/ 2.Нийтийн тээвэр зорчих тасалбарын төлбөр болон нийтийн тээврийн салбарт олгодог санхүүжилт тэдгээрийн эдийн засгийн үр нөлөөллийн судалгаа /эхлэлийн болон дундын тайлан боловсруулагдсан, гүйцэтгэл 80%/ 3.Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх урьдчилсан ТЭЗҮ /эхлэлийн тайлан боловсруулагдсан, гүйцэтгэл 40%/ 4.Их багтаамжийн нийтийн тээвэр болон автобус тээврийн чиглэлийн харьцуулсан судалгаа /гэрээ байгуулах шатанд/ 5.Дүүжин тээврийн төслийн нарийвчилсан ТЭЗҮ /тайлангийн шатанд байгаа, гүйцэтгэл 0%/ 6.Дүүжин тээврийн төслийн Баянхошуу-Ханын материал-Гэмтлийн эмнэлэг чиглэлийн зорчигчийн нягтрал, ашиг алдагдлын тооцоо судалгаа /эхлэлийн болон дундын тайлан боловсруулагдсан, гүйцэтгэл 80%/ 7.Нийтийн тээврийн чиглэл сайжруулалтын тооцоолол боловсруулах судалгааны ажлууд тус тус хийгдэж байна. /эхлэлийн болон дундын тайлан боловсруулагдсан, гүйцэтгэл 80%/	30

								Дээрх судалгааны ажлуудад тус газраас захиалагчийн хяналт тавих гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнтэй уялдуулан газрын даргын 2022 оны А/42 дугаар тушаалаар “Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний ажилд хяналт тавих” үүрэг бүхий 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Дээрх судалгааны ажлууд хийгдсэнээр мастер төлөвлөгөө боловсруулах суурь судалгааны үндэслэл болох юм.	
1.2	9.21.2. Зорчигч тээврийн урсгалаас хамаарч дагуул, хаяа хот, тосгод нийтийн тээврийн сүлжээнд холбогдсон байна.	-	Холбогдох дагуул, хаяа, хот, досгод тоо	2020	11	15		Улаанбаатар хотын хаяа дагуул 16 хот тосгодын 13 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 16 чиглэлд хүргэж, өдөр тутам 60 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. Мөн Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн шинээр баригдах “Аэро сити” буюу дагуул хотын нийтийн тээврийн үйлчилгээний 4 чиглэлийн төлөвлөлтийг боловсруулан батлуулсан.	90
1.3	9.21.3. Нийтийн тээврийн үйлчилгээнд олон төрөлт, ухаалаг зорчигч тээврийн төрөл нэмэгдсэн байна.	-	“Агаарын дүүжин тээврийн төсөл”-ийн чиглэлийн урт км	2020	0	10.1		Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/900 дүгээр захирамжаар 2 дугаар хавсралтаар Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний 7 ажлын жагсаалтыг баталсан. Дээрх ажлын зөвлөх үйлчилгээнд захиалагчийн хяналтыг Нийтийн Тээврийн газрын даргын 2022 оны А/42 дугаар тушаалаар нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний ажилд хяналт тавих ажлын хэсэг байгуулагдан 12 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх урьдчилсан ТЭЗҮ /эхлэлийн тайлан боловсруулагдсан, гүйцэтгэл 40%/, Дүүжин тээврийн төслийн нарийвчилсан ТЭЗҮ / тайлангийн шатанд байгаа, гүйцэтгэл 0%/ Дүүжин тээврийн төслийн Баянхошуу-Ханын материал-Гэмтлийн эмнэлэг чиглэлийн зорчигчийн нягтрал, ашиг алдагдлын тооцоо судалгаа /эхлэлийн болон	30

							дундын тайлан боловсруулагдсан, гүйцэтгэл 80%/ эхлэлийн болон дундын шатны тайланг хүлээн авч танилцан, санал, зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байгаа ба 2022 оны 05 дугаар 11-ний өдрийн 2/565, 2/566 дугаартай албан тоотуудаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт гэрээний дагуу зохих төлбөрийг олгуулах саналаа хүргүүлэн ажиллаж байна.
2.	Зорилт 9.22. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн, нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоолтой болно.						
2.1	9.22.1. Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй автобусаар парк шинэчлэлт хийсэн байна.	-	Байгаль орчинд ээлтэй автобусны тоо	2020	12	931	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Сүлдэрхан минералс ХХК болон "Xia men golden dragon bus" Co.,Ltd түншлэлтэй Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл (Улаанбаатар) "Нийтийн тээврийн парк шинэчлэлт"-ийн хүрээнд автобус нийлүүлэх НХААГ-21/015 дугаартай гэрээний дагуу 60 ширхэг их багтаамжийн автобус, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нь БНХАУ-аас Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 10 ширхэг давхар автобус, 1 ширхэг цахилгаан автобус, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Моннис Моторс" ХХК-тай байгуулсан 2020 оны НЗДТГ-20/А-463-2-01 дугаар гэрээний дагуу сургуулийн 20 ширхэг автобус нийт 91 автобусыг тус газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/51 дугаартай ажлын хэсэг хүлээн авч 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн үе шаттайгаар үйлчилгээнд ажиллуулж эхлээд байна. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Моннис Моторс" ХХК -тай байгуулсан 2020 оны НЗДТГ-20/А-463-2-01 дугаар гэрээний дагуу сургуулийн 20 ширхэг автобус Улаанбаатар хотод орж ирсэнтэй холбогдуулан Нийтийн тээврийн газрын даргын 2022 оны "Сургуулийн хүүхдийн автобус хүлээлцүүлэх ажлын хэсэг байгуулах тухай" А/41 дүгээр тушаалаар байгуулагдсан 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгөхөөр акт үйлдэн ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/190 дугаар захирамжаар Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх зорилтын хүрээнд цахилгаан хөдөлгүүртэй автобус нэвтрүүлэх тооцоо, судалгаа хийж, санал дүгнэлт

									боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэгт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр 2/253, 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр 2/387 дугаартай албан бичгүүдээр шаардлагатай тооцоо судалгааг хүргүүлсэн.	
2.2	9.22.2. Цахилгаан тээврийн хэрэгслийг цахилгаан эх үүсвэрээр цэнэглэх цэгийг байгуулсан байна.	-	Цахилгаан автобус цэнэглэх цэгийн тоо	2020	3	10			Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр нийтийн тээврийн парк шинэчлэлт, байгаль орчинд эзлэй ногоон хөгжлийн бодлогын хүрээнд цахилгаан хөдөлгүүртэй автобус нэвтрүүлэх чиглэлээр тооцоо, судалгаа хийж, санал боловсруулах "Ажлын хэсэг байгуулах тухай" А/190 дүгээр захирамжаар байгуулагдсан. Дээрх ажлын хэсэгт нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний 25 зогсоол орчимд цахилгаан автобус цэнэглэх цэг байгуулах схем зураг бүхий саналыг 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 2/253 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Дээрх саналын хүрээнд цахилгаан автобусыг цэнэглэх цэгийн газрын байршил, цахилгаан эх үүсвэр, зэрэг бусад нөлөөлөх хүчин зүйлийг холбогдох мэргэжлийн байгууллагууд судлах ажлууд хийгдэж байна.	30
2.3	9.22.3. Зорчигч тээврийн үйлчилгээний зогсоолыг сайжруулж, стандартын дагуу байгуулна.	-	Шинээр баригдах нийтийн тээврийн зогсоолын тоо	2020	930	980			1. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2021 онд хийгдэх автобусны дундын зогсоолыг 3 багц болгон хувааж гүйцэтгэсэн бөгөөд 1 багц ажлын төндөр нь 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр явагдаж "Өргөн говь" ХХК шалгарч Их хүрээ гудамжны урд, хойд байршилд "Мандала хотхон" нэртэй 2 зогсоолыг 2022 оны 06 дугаар сарын 20-ны дотор хийж дуусгахаар ажиллаж байна. 2. УИХ-ын гишүүн Ц.Мөнх-оргилын санаачлагаар Сүхбаатар дүүргийн 11-20 дугаар хороонд байрлах чиглэлийн тээврийн хэрэгслийн 15 дундын, 2 эцсийн зогсоолыг тохижуулах ажлыг "Үүлэн сүндэр" ХХК нь 2021 оноос хойш эхлэн гүйцэтгэж байна. Иж бүрэн тохижуулах Бэлхийн эцэс, Тоосгоны эцсийн 2 зогсоолын ажил бүрэн дууссан ба 15 дундын зогсоолын ажил хийгдэж гүйцэтгэл 60 хувьтай байна. 3. УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар гишүүний санаачлагаар Зам тээврийн сайдын багцаар Чингэлтэй дүүргийн Хайлааст, Дэнжийн мянгийн авто замд чиглэлийн тээврийн хэрэгслийн 19 зогсоолыг тохижуулахаар "Цагаан толгойн нуур" ХХК шалгарч 6 зогсоолын ажлыг хийж дууссан ба ажлын гүйцэтгэл 20 хувьтай байна.	70

	<p>4. Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар Чингэлтэй дүүргийн 17, 18-р хороонд Чингэлтэйн 5.1 км авто замыг шинэчлэх ажлын хүрээнд 2 эцсийн зогсоол, 17 дундын зогсоолыг тохижуулах ажлын зураг төсөлд саналаа тусгуулан ажиллаж байна. Зам талбайн ажил одоогоор эхлээгүй байна.</p> <p>5. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/259 дүгээр захирамжаар 2022 онд Нийслэлийн гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдийн тав тухтай зорчих нөхцөлийг хангах үүднээс 6 эцсийн зогсоол, 36 дундын зогсоолыг тохижуулах саналыг 2022 оны 02 дугаар сарын 28 ны өдөр 2/233 тоот албан бичгээр, мөн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 2/536 тоот албан бичгээр 100 зогсоолын байршлыг тогтоож Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсэн.</p>					<p>Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны 64 зогсоолоор дайран өнгөрөх чиглэлүүдийн мэдээллийг шинэчлэн хэвлэлийн эх бэлтгэж хэвлэлтэд өгсөн.</p>	50
			2020	3	253	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/259 дүгээр захирамжаар 2022 онд Нийслэлийн гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдийн тав тухтай зорчих нөхцөлийг хангах үүднээс 6 эцсийн зогсоол, 36 дундын зогсоолыг тохижуулах саналыг 2022 оны 02 дугаар сарын 28 ны өдөр 2/233 дугаартай албан бичгээр, мөн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 2/536 дугаартай албан бичгээр 100 зогсоолын байршлыг тогтоож Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсэн.</p>	50
3.	Зорилт 9.23. Улаанбаатар хотод ачаа тээврийн логистик, зорчигчийн ая тухтай зорчих нөхцөлийг хангасан зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна.						

3.1	9.23.1. Улаанбаатар хотын зүүн баруун хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна.	-	Зорчигчийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорчигчийн нэгдсэн терминалын тоо	2020	0	2	-	0
Дундаж хувь: $90\%*1+70\%*1+50\%*2+40\%*1+30\%*3+0\%*1$								
43,3								

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.САЙХАНБЯАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭЖ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б. Болорцэцэг
Б.БОЛОРЦЭЦЭГ